



# СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№148 /362/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.08.22

Цаг үе, үйл явдал

## УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ЦЭРЭГ-СПОРТЫН “ДӨЛ” ЦОГЦОЛБОР ТЭМЦЭЭН ЭХЭЛЛЭЭ



Хүүхэд, залуучуудад цэрэг-эх оронч үзэл төлөвшүүлэх, бие бялдрын болон ёс суртахуун, сэтгэл зүйн хүмүүжил олгох, эх орноо батлан хамгаалах бэлтгэл эзэмшүүлэх зорилготой Батлан хамгаалахын сайдын нэрэмжит улсын аварга шалгаруулах цэрэг-спортын “Дөл”

цогцолбор тэмцээн өнөөдрөөс 27-ны өдрийн дуустал Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төвд зохион байгуулагдана. Аймаг, нийслэлийн ерөнхий боловсролын сургуулиудаас шалгарсан баг тамирчид Таван толгойд байрласан бөгөөд өнөөдөр батлан хамгаалах

салбарын соёл, сурталчилгааны өдөрлөгөөр “Дөл” цогцолбор тэмцээний үндсэн үйл ажиллагаа эхэлнэ. Тус өдөрлөгийн үеэр Монгол цэргийн музей нүүдлийн музейгээ дэглэж, ЗХЖШ зэвсэг техникийн үзэсгэлэн гаргаж, Зэвсэгт хүчний үйл ажиллагааны талаар

сурталчилгаа хийж, Нийслэлийн цэргийн штаб цэргийн алба, ҮБХИС элсэлтийн шалгалт, сургуулийн үйл ажиллагааны талаар мэдээлэл өгч, ЦДБЭЧ бүрэн хэмжээний тоглолтоо сонирхуулах ажээ.

### ЦАГ АГААР

УЛААНБААТАР

| ӨДӨР  | ШӨНӨ  |
|-------|-------|
| ☀️ 23 | 🌧️ 11 |

ӨМНӨД СУДАН

| ӨДӨР  | ШӨНӨ  |
|-------|-------|
| ☀️ 28 | 🌧️ 23 |

### ВАЛЮТЫН ХАНШ

| ВАЛЮТ  | АВАХ     | ЗАРАХ    |
|--------|----------|----------|
| USD 🇺🇸 | 3,184.00 | 3,210.00 |
| EUR 🇪🇺 | 3,162.00 | 3,267.00 |
| CNY 🇨🇳 | 467.60   | 478.00   |
| RUB 🇷🇺 | 45.00    | 57.80    |
| JPY 🇯🇵 | 23.35    | 24.06    |
| KRW 🇰🇷 | 2.30     | 2.46     |

### ЗУРХАЙ



2022.08.22 /ДАВАА ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 26

**ЗУНЫ АДАГ УЛААГЧИН ХОНЬ САР**

**ГУРВАН ХӨХ МЭНГЭТЭЙ УЛААГЧИН ХОНЬ ӨДӨР**

**Үс засуулбал:**

**ЖАРГАЛ ҮРГЭЛЖИД ИРНЭ**

**НАРАН УРГАХ, ШИНГЭХ:**

**05.56-19.54**

**БАРИЛДЛАГА:**


**РАШААН**

**ШҮТЭН БАРИЛДЛАГА:**

**Хуран үйлдэхүй**

**Суудал: Ус**

## ТОРГОН ЦЭРГҮҮДИЙНХЭЭ ТӨРСӨН ӨДРИЙГ ТЭМДЭГЛЭЛЭЭ



Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн Эмэгтэйчүүдийн зөвлөлөөс өнөөдөр V-VIII сард төрсөн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчдынхаа төрсөн өдрийг тэмдэглэлээ. Захирагчийн нэгдүгээр орлогч, штабын дарга хошууч Д.Хашхүү дайчдад төрсөн өдрийн баярын мэндчилгээ хүргэн үг хэлж, хүндэтгэлийн үйл ажиллагааг эхлүүлсэн юм.

Хорвоод мэндэлсэн хосгүй баяр нь тохиож буй цэрэг дайчдад ангийн эмэгтэйчүүд болон ХХТР-ын морьт салааны ахлагч ахлах ахлагч Я.Бямбасүрэн, ХУТР-ын салааны захирагч дэслэгч Х.Дамдиндорж, байлдагч А.Энх-Амар, Б.Жигмэд нар ая дууны мэндчилгээ өргөн дэвшүүлснээс гадна ангийн гал тогооныхон амтлаг хоол, амттангаар бэлэг бариллаа.

Ахмад О.ГЭРЭЛЗАЯА



**КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД**

**Тохиолдол**

Нийт: 592,129,086

**Эдгэрсэн**


Нийт: 563,986,818

**Нас барсан**

Нийт: 6,444,786

Цахим шууданд

# АВЪЯАСЛАГ ЦЭРГИЙН АЛБА ХААГЧ



хатуужил сууж, аливаа ажлыг хурдан шуурхай хийж, биеэ зөв боловсон авч явах, харилцах талаар өөртөө итгэлтэй, итгэл төгс болж байна" гэсэн юм. Түүний хэлэх дуртай үг "Бид оршин байж, би оршино". Энэ үгээрээ "Би" гэдэг хүн бол ямар ч хүч байхгүй. "Бид" байж, бусдыгаа бодож байж, бусад хүн намайг хүндэлнэ гэдгийг ойлгосон гэдгээ илэрхийлээд "Үеийн залуучууд болон дүү нартаа цэрэгт яваарай гэж хэлмээр байна" гэж дахин дахин дамжуулсан шүү.

Мөн "Ирээдүйд гэр бүлээ толгойлж явахдаа хэр амжилттай байх зэрэг чадварыг эндээс л олж авна гэдэгт итгэлтэй байна. Эр хүнд байх ёстой зориг, тэсвэр тэвчээр, хатуужил болон амьдралын ухааныг цэргийн алба хааснаар сайн суралцаж мэдэж авна гэдгийг хэлмээр байна" гэдэг ярилцлагаа өндөрлүүлсэн юм. Өөрийгөө олж яваа авьяаслаг байлдагчийн маань цаашдынх нь хүсэл мөрөөдөл, зорилгодоо хүрэх зам нь шулуун дардан байх болтугай. Эр цэргийн албаа нэр төртэй хаагаад хайртай аав, ээж ах, эгч, дүү нартайгаа бахархалтайгаар уулзахыг хүсэн ерөөе.



**Зэвсэгт хүчний 013 дугаар ангийн Соёл хүмүүжлийн зааварлагч ахлах ахлагч Н.УУГАНЦЭЦЭГ**

Энэ удаа бид Зэвсэгт хүчний 013 дугаар ангийн авьяаслаг цэргийн алба хаагч байлдагч М.Мөнхжаргалыг онцолж байна. Тэрээр Ерөнхий боловсролын дунд сургуулиа дүүргээд СУИС-ийн РТМУС-ийн кино механикч мэргэжлээр суралцаж эхэлсэн ч жилийн чөлөө авч, эр цэргийн албанд татагдан ирсэн байна.

Авьяаслаг байлдагч М.Мөнхжаргалын амжилтуудаас дурдвал Street dance, Латин америк төрлөөр бүжиглэдэг. "Солонгон хүн" сэдвээр Кино тэмцээнд оролцож, 5 дугаар байр, "Бяцхан мастерууд" реалити шоу нэвтрүүлэгт оролцон Шилдэг бүжигчин, 2019 оны улсын аварга шалгаруулах MONGOLIAN CHEERLEADING бүжгийн тэмцээнд хамтлагаараа тэргүүн байр эзэлж, АНУ-д болох олон улсын CHEERLEADING тэмцээнд оролцох эрх авч байжээ. 2021 оны "LEVEL UP HIPHOP DANCE BEGINNER BATLL" бүжгийн тэмцээнд оролцож, дэд байр тус тус эзэлж байсан байна.

Тэрээр цэргийн албанд ирээд ч урлаг соёлын үйл ажиллагаанд тогтмол оролцож байна. Тухайлбал, 2021 оны Тангаргийн баяраараа бүжиглэж, шинэхэн цэрэг дайчдадаа мэндчилгээ дэвшүүлсэн бол Зэвсэгт хүчний "Монгол түмний уламжлалт их баяр-цагаан сар" тэмцээн, Зэвсэгт хүчний аварга шалгаруулах марш тактикийн тэмцээнд амжилттай оролцсон баг тамирчдадаа зориулж, өөрийн авьяас чадвараа толилуулсан билээ.

Тэрбээр "Цэргийн албанд татагдан ирэхээсээ өмнө урлаг, уран сайхан хөөцөлдөөд, эр хүний тэсвэр тэвчээр шаардах ажлуудад их тааруу байсан. Цэргийн албанд ирээд



## МОНГОЛ ЦЭРГИЙН МУЗЕЙН БЯЦХАН ҮЗЭГЧИД



бяцхан үзэгчдийн хөл ихтэй байна. Монгол Улсын цэргийн түүх, соёл уламжлалтай танилцхаас гадна үндэсний уламжлалт тоглоом шагай наадгай, хорол тоглоом модон бараар барлах тухай ихэд сонирхон үзэж байгаа нь тус үзэсгэлэнгийн эх орноо сурталчилах эрхэм зорилго биелэгдэж байгаа харуулна.

ОХУ-д жил бүр зохион байгуулагддаг Цэргийн наадмын "Армийн соёл, урлаг" тэмцээнд Монгол Улсын Зэвсэгт хүчний соёл урлагийн байгууллага төдийгүй Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг музейнүүдийнхээ төлөөлөл болж Монгол цэргийн музей анх удаа музейн үзэсгэлэнгийн төрлөөр оролцож байгаа.

Монгол цэргийн музейгээс гаргасан АРВАНГУРАВДУГААР ЗУУНЫ МОРЬТОН ДАЙЧИД үзэсгэлэн үзэгчдийн сонирхлыг ихээхэн татаж, ялангуяа



# АЛАГ НҮДЭН ХҮҮДЭЭ УДАХГҮЙ ОЧИХ ЭХ ОРНЫ ХҮҮ



ангид 2021 оны II ээлжээр хугацаат цэргийн албанд татагдан алба хааж байна.

Хугацаат цэргийн алба хаах хугацаандаа үе тэнгийн залуусаас удирдан зохион байгуулах, манлайлах чадвар, цэргийн хэргийн мэдлэгээрээ онцгойрон I мотобуудлагын I салааны бага дарга хэмээх эрхэм үүргийг гүйцэтгэж байна. Тэрээр алба хааж буй энэ хугацаандаа Тангаргийн баярын анхны буудлагаараа "Онц буудагч", ангийн захирагчийн 2022 оны тушаалаар дэд түрүүч цол, ЗХЖШ-ын цогцолбор шалгалтаар "Улсын хил орчимд мотобуудлагын ротын тактикийн бүлгээр цэргийн ажиллагаа явуулах" буудлагад тасгийн захирагчийн үүргийг амжилттай гүйцэтгэж, "Онц сурлагатан" тэмдгээр шагнагдсан.

Тэрээр хугацаат цэргийн алба хааснаар төлөв даруу занг өөртөө бий болгож, удирдан зохион байгуулах чадвартай болж, чадсандаа баяртай байгаагаа илэрхийлэхийн ялданд үе тэнгийн залуустаа хугацаат цэргийн албаа хаахыг уриалсан юм.

**Зэвсэгт хүчний 167 дугаар анги. Дэслэгч Б.БАТЗАЯА**

I мотобуудлагын ротын I мотобуудлагын салааны II тасгийн захирагч дэд түрүүч Ц.Нандинболор нь 2000 онд айлын ууган хүү болон мэндэлжээ. 2006-2017 онд Өмнөговь аймгийн Даланзадгад сумын I бүрэн дунд сургуулийг төгсөж, ХААИС-д суралцаж байгаад БНМАУ-ын баатар, хурандаа генерал Ж.Лхагвасүрэнгийн нэрэмжит Зэвсэгт хүчний 167 дугаар



## Гэрэл зураг—нэг агшин



**"Аравт" морин цэргийн уралдаан амжилттай оролцсон Зимбабве Улсын баг, тамирчид**